МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ИЖ БҮРЭН АУДИТ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРАМ НИЙЦҮҮЛЭН ХИЙЖ ЗӨВЛӨМЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1	Ажлын даалгавар боловсруулах үндэслэл	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын I үе шат (2021-2030): "Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх үе", III үе шат (2041-2050): "Технологийн дэвшил, ур чадвартай хүний нөөц, цахим худалдаанд тулгуурлан дэлхийд өрсөлдөх чадвартай, инновацад суурилсан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх үе", Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем) Зорилт 5.3. "Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ." Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн I үе шат (2021- 2030): "Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе", Зорилго 5. "Монгол хүний хөгжпийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр- хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа ..." нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шинэчлэлийн суурийг тогтвортой эхлүүлэх; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.4.6-д заасан "цахим систем, түүний бүрэлдэхүүн хэсгийн хэвийн үйл ажиллагааг хариуцан, цахим системийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг тогтмол нэмэгдүүлэх" чиг үүргийг хэрэгжүүлэх; Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор худалдан авах ажиллагаанд хиймэл оюун нэвтрүүлэх замаар хүний оролцоог бууруулах бодлогын баримт бичиг, хөгжүүлэх зааварчилгааг боловсруулах үйлчилгээг сонгох. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 Оны 07 Сарын 25 Өдрийн "Засгийн Газраас Шуурхай авч

		хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Ажлын 4.4 заасан заалт болох /Тодорхой Хугцаанд Байнга Худалдан Авдаг Чанар, Стандартын Шаардлага Хангасан Бараа, Үйлчилгээг Бодит Үнээр Худалдан авах боломжийг бүрдүүлэн төрийн Худалдан авах ажилгааны "Цахим Дэлгүүр"-т байршуулах
2	Ажлын хамрах хүрээ	Төрийн худалдан авах ажилгааны газрын мэдээллийн технологийн орчинд ажиллаж буй биет болон виртуал сервер, Цахим систем болох www.tender.gov.mn байна.
3	Захиалагч байгууллага	Төрийн худалдан авах ажиллагааны газар
4	Төсөвт өртөг	650,980,000.0 /зургаан зуун тавин сая есөн зуун наян мянга / төгрөг
5	Гүйцэтгэх ажил	**1. Мэдээллийн аюулгүй байдлын удирдлага ба нийцэлт** Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, стандарт, журам, зааврыг хянах. Холбогдох хууль, дүрэм, стандартын дагуу аудит хийх, тухайлбал: Монгол Улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль Байгууллагын нууцын тухай хууль Ажилтнуудын мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, сургалтын хөтөлбөрийг үнэлэх. **2. Танилт ба Хандалтын удирдлага (IAM)** Хэрэглэгчийн дансны амьдралын мөчлөгийг удирдах (шинэ данс үүсгэх, өөрчлөх, устгах). Нэвтрэх болон зөвшөөрлийн механизмын үнэлгээ. Эрх бүхий хэрэглэгчийн удирдлага. Танилт болон лавлах үйлчилгээний аюулгүй байдал **3. Сүлжээ ба дэд бүтцийн аюулгүй байдал** Дотоод болон гадаад сүлжээний аюулгүй байдлын үнэлгээ. Файрволл, IDS/IPS, сүлжээнд сегментаци хийх хяналт. Сүлжээний төхөөрөмжүүдийн тохиргоо (router, switch, firewall). Холын нэвтрэлт, VPN, утасгүй сүлжээний аюулгүй байдал. **4. Эмзэг байдал ба аюулгүй байдлын шалгалт**

		Эмзэг байдлын үнэлгээ ба нэвтрэлтийн шалгалт (дотоод, гадаад). Програм хангамж, системийн patch менежмент. Аюулгүй байдлын шалгалт ба засварын үр дүнгийн үнэлгээ. **5.Системийн тасралтгүй байдал ба сэргээх төлөвлөгөө** Бизнесийн тасралтгүй ажиллагаа (BCP) ба ослын сэргээх (DR) стратеги. Нөөцлөлт ба сэргээх механизм. Өндөр хүртээмжтэй, failover системийн тохиргоо. Тасралтгүй ажиллагаа ба сэргээх төлөвлөгөөг турших. **6.Аюулгүй хөгжүүлэлт (SDLC)** Програм хангамж хөгжүүлэх мөчлөгт аюулгүй байдлыг нэгтгэх. Програмын аюулгүй байдлын тест (код шалгалт, application scan). Гуравдагч талын хөгжүүлэлт ба үйлчилгээний аюулгүй байдлын шаардлага. **7.Өөрчлөлт ба конфигурацийн удирдлага** Өөрчлөлтийн удирдлагын бодлого, үйл явц. Конфигурацийн суурь стандарт ба аюулгүй суурилуулалт. Өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд үүрэг, эрх хуваарилалт. **8.Лог бүртгэл, хяналт ба зөрчилд хариу арга хэмжээ** Лог бүртгэл ба хадгалах журмыг үнэлэх. SIEM эсвэл хяналтын системийн боломжуудыг үнэлэх. Зөрчил илрүүлэх, хариу арга хэмжээ авах, тайлагнах үйл ажиллагаа. Кибер халдлагад хариулах бэлэн байдал (playbook, эскалацийн замууд). **9.Эрсдэлийн удирдлага ба тасралтгүй сайжруулалт** Байгууллагын эрсдэлийн үнэлгээний аргачлал. Эрсдэлийн бүртгэл, risk register-ийн удирдлага. Аюулгүй байдлын хяналтыг тогтмол мониторинг хийх. Эрсдлийг удирдах үүрэг хариуцлагыг тодорхойлох.

		10.Биет ба орчны аюулгүй байдал Чухал дэд бүтцийн физик хамгаалалт. Хандалтын хяналт, CCTV, галын аюулгүй байдал, орчны хамгаалалт.
6	Шаардлага, шалгуур үзүүлэлт	Кибер аюулгүй байдлын ахлах аудитор Тухайн мэргэжлээрэй ажилсан жил 15 дээш жил Мэдээллийн технологи, Компьютерийн шинжлэх ухааны магистр болон түүнээс дээш Олон улсын Аудиторын эрх Ур чадварын сертификат: Red Hat Expert Certificate (үндсэн ажилтан) Кибер аюулгүй байдлын шинжээч Тухайн мэргэжлээрэй ажилсан жил 5 дээш жил Мэдээллийн технологи, Компьютерийн шинжлэх ухааны баклавр болон түүнээс дээш Ур чадварын сертификат: eCPPTv2 (үндсэн ажилтан эсвэл гэрээт ажилтан) Мэдээллийн системийн шинжээч Тухайн мэргэжлээрэй ажилсан жил 5 дээш жил Мэдээллийн технологи, Компьютерийн шинжлэх ухааны баклавр болон түүнээс дээш Ур чадварын сертификат: Систем администратор (үндсэн ажилтан эсвэл гэрээт ажилтан)
7	Тайлан	Кибер аюулгүй байдлын аудитын тайлан нь ойлгомжтой, цэгцтэй байх товч бөгөөд шаардлагатай гол мэдээллүүдийг агуулсан байх аудитын үр дүнг бүрэн тусгасан байх зөрчилийг арилгах зөвлөмжийг тусгасан байх англи болон Монгол хэл дээр тус тус боловсруулсан байна.
8	Гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоног байна.
9	Тайлагнах үе шат	Ажил дууссанаас хойш 30 хоногийн дотор ажлын тайланг Төрийн худалдан авах ажиллагааны газрын удирдлага, холбогдох албан хаагчдад танилцуулан, хэлэлцүүлж, 2 хувь хүлээлгэн өгнө.
10	Бусад нөхцөл, шаардлага	Ажлын даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө, гүйцэтгэх хуваарь ирүүлнэ. Санхүүжилтийг 2 хувааж өгөх ба төлөвлөгөөг харгалзан үзнэ.

---oOo---